



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/158/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2025 оны 02 дүгээр сарын 7</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал.....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	9
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	12
4.1 Ерөнхий зүйл.....	12
4.2 Материаллаг байдал .....	13
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт. ....	13
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	14
4.5.1 Завсрын аудитын талаар .....	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	14
5. Аудитын илрүүлэлт.....	14

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2025.02.07 № 2/04  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолд 2023 оны 312 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт орсны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/08 дугаар захирамжаар “Баянхонгор аймгийн

**5020125**

худалдан авах ажиллагааны газрын бүтэц орон тоо"-г баталж тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 28 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 99.6 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>4,710,440.00</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	00.00	4,710,440.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	00.00	4,710,440.00
35410	Бичиг хэргийн материал	00.00	561,260.00
35420	Аж ахуйн материал	00.00	3,909,180.00
35440	Түлш, шатах тослох материал	00.00	240,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>32,367,573.12</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	00.00	32,367,573.12
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	00.00	31,652,573.09
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	00.00	39,699,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-14,061,052.68
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	00.00	10,490,520.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-4,476,494.23
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	00.00	715,000.03
39301	Програм хангамж	00.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-164,999.97
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	00.00	37,078,013.12
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	00.00	37,078,013.12
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	37,078,013.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>00.00</b>	<b>358,957,542.39</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>21,588,488.89</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	21,588,488.89
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,050,105.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,050,105.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>337,369,053.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	27,232,453.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	27,232,453.50
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	310,136,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	310,136,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>00.00</b>	<b>321,879,529.27</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>321,879,529.27</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	00.00	284,652,249.42
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	00.00	225,157,804.00
210101	Үндсэн цалин	00.00	119,452,479.00
210102	Нэмэгдэл	00.00	84,569,108.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,466,000.00
210104	Урамшуулал	00.00	9,670,217.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	00.00	28,144,715.01
210201	Тэтгэврийн даатгал	00.00	19,138,406.06
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,251,577.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,125,788.62
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,125,788.62
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,503,154.47
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	00.00	8,821,570.64
210401	Бичиг хэрэг	00.00	3,377,340.00

**Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210402	Тээвэр, шатахуун	00.00	3,510,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,445,730.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	348,200.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	140,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>8,084,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	8,084,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00.00</b>	<b>5,196,749.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,196,749.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>9,247,410.77</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,071,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	00.00	8,175,910.77
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>37,227,279.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>27,732,453.50</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	27,232,453.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>9,494,826.35</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,494,826.35
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>00.00</b>	<b>345,419,158.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>8,050,105.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>8,050,105.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	8,050,105.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	8,050,105.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>337,369,053.50</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>27,232,453.50</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	27,232,453.50
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>00.00</b>	<b>310,136,600.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	310,136,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>00.00</b>	<b>316,815,158.50</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>316,815,158.50</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>279,587,878.65</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>00.00</b>	<b>225,157,804.00</b>
210101	Үндсэн цалин	00.00	119,452,479.00
210102	Нэмэгдэл	00.00	85,362,325.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	11,466,000.00
210104	Урамшуулал	00.00	8,877,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>00.00</b>	<b>28,144,715.01</b>
210201	Тэтгэврийн даатгал	00.00	19,138,406.06
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,251,577.24
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,125,788.62
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	1,125,788.62
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,503,154.47
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>00.00</b>	<b>9,577,110.64</b>

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан			
210401	Бичиг хэрэг	00.00	2,748,600.00
210402	Тээвэр, шатахуун	00.00	3,750,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	1,788,930.64
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	1,289,580.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>00.00</b>	<b>1,166,000.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	176,000.00
210604	Урсгал засвар	00.00	990,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>00.00</b>	<b>8,084,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	00.00	8,084,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>00.00</b>	<b>5,636,749.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	5,196,749.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	440,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>00.00</b>	<b>1,821,500.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	1,821,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>00.00</b>	<b>37,227,279.85</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>27,732,453.50</b>
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00.00	27,232,453.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	500,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>00.00</b>	<b>9,494,826.35</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	9,494,826.35
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>28,604,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>28,604,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>28,604,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>00.00</b>	<b>28,604,000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	28,604,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-28,604,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	00.00	00.00
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00

**Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	37,078,013.12	37,078,013.12
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>	<b>37,078,013.12</b>	<b>37,078,013.12</b>

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	316,136,600.00	308,691,878.65	7,444,721.35	97.6
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	316,136,600.00	308,691,878.65	7,444,721.35	97.6
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	315,136,600.00	308,191,878.65	6,944,721.35	97.8
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	230,877,000.00	225,157,804.00	5,719,196.00	97.5
210101	Үндсэн цалин	120,853,900.00	119,452,479.00	1,401,421.00	98.8
210102	Нэмэгдэл	89,403,900.00	85,362,325.00	4,041,575.00	95.5
210103	Унаа хоолны хөнгөлөлт	11,742,200.00	11,466,000.00	276,200.00	97.6
210104	Урамшуулал	8,877,000.00	8,877,000.00	0.00	100.0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,859,600.00	28,144,715.01	714,884.99	97.5
210201	Тэтгэврийн даатгал	19,624,500.00	19,138,406.06	486,093.94	97.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,308,800.00	2,251,577.24	57,222.76	97.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,154,400.00	1,125,788.62	28,611.38	97.5
210204	Ажилгүйдлийн даатгал	1,154,400.00	1,125,788.62	28,611.38	97.5
210205	Эрүүл мэндийн даатгал	4,617,500.00	4,503,154.47	114,345.53	97.5
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	9,880,000.00	9,577,110.64	302,889.36	96.9
210401	Бичиг хэрэг	2,750,000.00	2,748,600.00	1,400.00	99.9
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	3,750,000.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,080,000.00	1,788,930.64	291,069.36	86.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,300,000.00	1,289,580.00	10,420.00	99.2
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	28,900,000.00	28,890,000.00	10,000.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	21,900,000.00	21,900,000.00	0.00	100.0
210602	Тавилга	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	1,000,000.00	990,000.00	10,000.00	99.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,100,000.00	8,084,000.00	16,000.00	99.8
210702	Дотоод албан томилолт	8,100,000.00	8,084,000.00	16,000.00	99.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,520,000.00	6,516,749.00	3,251.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,200,000.00	5,196,749.00	3,251.00	99.9
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,320,000.00	1,320,000.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2000000.00	1821500.00	178,500.00	91.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,821,500.00	178,500.00	91.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1000000.00	500000.00	500,000.00	50.0
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан					
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	316,136,600.00	308,691,878.65	7,444,721.35	97.6
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	310,136,600.00	302,691,878.65	7,444,721.35	97.6
132001	Орон нутгийн төсвөөс	310,136,600.00	302,691,878.65	7,444,721.35	97.6
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,000,000.00	6,000,000.00	0.00	100.0
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	8	7	1	87.5
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	5	4	1	80.0
620003	Үйлчлэх ажилтан	2	2	0	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	27,232,453.50
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	27,232,453.50
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	27,232,453.50
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	27,232,453.50
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	27,232,453.50
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	27,232,453.50
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	27,232,453.50
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

“Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц орон тооны хязгаарыг тогтоох тухай” Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 4 дэх заалтад Засгийн газрын 2023 оны 312 дугаар тогтоолоор 4.26 дахь дэд заалт нэмсний дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/08 дугаар захирамжаар “Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газрын бүтэц орон тоо”-г баталж тайлант онд шинээр үүсгэн байгуулагдсан.

Тус байгууллага нь “Худалдан авах ажиллагааг ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагаанд итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлэхэд оршино” гэсэн зорилгын дор үйл ажиллагаагаа явуулж байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын

сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Баянхонгор аймгийн худалдан авах ажиллагааны газар нь аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтсээс баталсан “Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг дагаж мөрдөж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны 01 сарын 17-ны өдөр шинээр үүсгэн байгуулагдсан ба 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 37,078.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	-	4,710.4	4,710.4
Үндсэн хөрөнгө	-	51,070.1	51,070.1
Хуримтлагдсан элэгдэл	-	(18,702.5)	(18,702.5)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>0.00</b>	<b>37,078.0</b>	<b>37,078.0</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	-	37,078.0	37,078.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>0.00</b>	<b>37,078.0</b>	<b>37,078.0</b>

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 4,710.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 10,487.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан ба аймгийн Орон нутгийн өмчийн газраас 1,598.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авч, үйл ажиллагаандаа 7,235.4 мянган төгрөгийн хөрөнгө

зарцуулж байгууллагын даргын тушаалаар 140.3 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 51,070.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь төсвийн хөрөнгөөр 28,604.0 мянга төгрөгийн хөрөнгө худалдан авсан, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 04 дүгээр захирамжаар аймгийн Орон нутгийн өмчийн газраас 24,720.7 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлэн авсан ба тус байгууллагын даргын 2024 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А/34 дүгээр тушаалаар ашиглалтын хугацаа дууссан дахин ашиглагдах боломжтой өмнө нь байгууллагад ашиглагдаж байсан 4,376.2 мянган төгрөгийн хөрөнгийг 2,121.6 мянган төгрөгөөр дахин үнэлж орлого авч Аймгийн ИТХ-ын 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 2/13 дугаар тогтоолоор 2,429.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж устгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 37,078.0 мянган төгрөг болж 37,078.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 37,078.0 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2024 оны 01 дүгээр сарын 17-д үүсгэн байгуулагдсан тул төсвийн төслийн санал хүргэгдэж байгаагүй.

Тайлант онд 315,136.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж үйл ажиллагаагаа явуулсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 315,136.6 мянган төгрөг батлагдсанаас 308,191.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 308,691.9 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 6,944.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	80801 үндсэн үйл ажиллагаа зардал	315,136.6	308,191.9	6,944.7	98%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,000.0	500.0	500.0	50%
	Нийт дүн	316,136.6	308,691.9	7,444.7	98%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас 6,944.7 мянга буюу 2.2 хувь, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 500.0 мянга нийт 7,444.7 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд Орон нутагт тасралтгүй 5 жил ажилласан төрийн захиргааны албан хаагчдад олгох 6 сарын урамшуулалд аймгийн Орон нутгийн өмчийн газраас шилжин очсон албан хаагчийн 27,232.5 мянган төгрөгийн санхүүжилт орж ирсэн.

Хүснэгт 3. Нэмэлт санхүүжилтийн орлого /мян.төг/

Д/д	Орлогын нэр төрөл	Авсан санхүүжилт
1	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж	27,232.5
	Нийт дүн	27,232.5

Эх сурвалж: Нэмэлт санхүүжилтийн дансны хуулга

Дээрх орж ирсэн тус байгууллагын даргын 2024 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн Б/13 тоот тушаалаар 4 албан хаагчид 27,232.0 төгрөгийн тэтгэмж олгосон байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Худалдан авах ажиллагааны газар нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 12 дүгээр сарын 11-ний өдөр ирүүлсэн.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Н.Бямбадорж, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Мөнхтуяа нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны батлагдсан төсвийн нийт зардлын 315,136.6 мянган төгрөгөөс тооцоход 3,151.4 мянган төгрөг байгаа ба гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 2,048.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.**

Тухайн байгууллага нь Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 345,419.2 мянган төгрөгийн 18 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 44,068.7 мянган төгрөгийн 8 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 49,199.2 мянган төгрөгийн 20 мэдээллийг бүрэн байршуулсан байна.

##### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Тус байгууллага нь шинээр үүсгэн байгуулагдсан тул өмнөх онд аудит хийгдээгүй.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй.

#### **5. Аудитын илрүүлэлт**

Аудитаар алдаа зөрчил илрээгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oO-----